



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 4/72

Хужирт сум

Гамшгаас хамгаалах бүх нийтийн
бэлэн байдлын зэргийг бууруулж өндөржүүлсэн
бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “в”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Коронавируст халдварт (ковид-19)-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ын 2.1.4, 3.3 дахь хэсгийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Суманд Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлын халдварт сүүлийн 14 хоногийн хугацаанд бүртгэгдээгүй тул гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэргийг бууруулан улбар шар түвшинд шилжиж сумын хэмжээнд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн итгээдийг 2021 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн 06⁰⁰ цагаас эхлэн 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 06⁰⁰ цаг хүртэл Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Бэлэн байдлын зэрэг буурсантай холбогдуулан сумын төвөөс орох, гарах хөдөлгөөнийг хязгаарлах байнгын хяналтын 6 цэгийг 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдөр хүртэл ажиллуулсугай.

3. Банк, хүнс, барааны дэлгүүр, эмийн сангийн ариутгал халдвартайжүүлэлтийг хангуулан 2021 оны 5 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн банкны салбарыг 09.00- 18.00 цаг, хүнс, барааны дэлгүүр, эмийн санг 10.00-18.00 цагийн хязгаарлалттай тус тус ажиллуулсугай.

4. Үйлчилгээ авч байгаа иргэдийг бүртгэл хяналтын системд бүртгэн халдварт хамгааллын дэглэмийг мөрдөж ажиллахыг үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, үйчилгээний газрын эздэд, иргэдэд үйлчилгээ үзүүлэхдээ халдварт хамгааллын дэглэм баримталж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга, дэд хурандаа (Х.Түмэнбаяр), Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Доржсэмбэ) нар тус тус үүрэг болгосугай.

5. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын 5-10 хувийг ажлын байран дээр бусад албан хаагчдыг цахимаар ажиллуулсуй.

6. Тусгай чиг үүргийн байгууллага, ерөнхий боловсролын сургууль, банк, эрүүл мэндийн төв, хүнс, барааны дэлгүүр, эмийн сан, шатахуун түгээх станц, уст цэгээс бусад төрийн болон аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр хориглосугай.

7. Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн сурагчдыг элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх зорилгоор 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн халдварт хамгааллын дэглэмийг баримтлан танхимын давтлага хийлгэсүгэй.

8. Хөдөөгийн иргэдийг хяналтын постонд бүртгэж, тодорхой цаг тогтоон сумын төв рүү нэвтрүүлж буцаах арга хэмжээг авсугай.

9. Архи, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэхийг 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 06.00 цаг хүртэл хориглосугай.

10. Улаанбаатар хот болон халдвартай бусад бүсээс хувийн ажлаар суманд ирэх иргэдийг PCR шинжилгээг үндэслэн нэвтрүүлж, 14 хоног тусгаарлан ажиглах байранд байх болон 6 дахь хоногт түргэвчилсэн оношлуураар шинжилгээ өгөх төлбөрийг тухай иргэнээр хариуцуулсугай.

11. Иргэдэд халдвараас сэргийлэх, хамгаалах талаар байнгын зөвлөгөө, зөвлөмж, сээрэмжлүүлэг өгч ажиллахыг Эрүүл мэндийн төвийн эрхлэгч (Э.Оюунпүрэв)-д үүрэг болгосугай.

12. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга (Б.Дэмбэрэл), Цагдаагийн тасгийн дарга, дэд хурандаа (Х.Түмэнбаяр) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Т.БАЯРМӨНХ